

**УЛС ТӨР**

Д.СОСОРБАРАМ: КОМУНИСТУУД ТӨРИЙН ТОЛГОЙД ГАРАХААРАА Л ХҮНД ЯЛ ТУЛГАЖ, АЖЛАА БҮТЭЭДЭГ АРАНШИНТАЙ

II нүүрт

**ХЭН НЬ ХЭН БЭ**

НАЙРААТАЙ, НАМЫНХАА “ЭРХИЙН ТЭНЭГ”

V нүүрт

Дугаарын **60** мөр

Дөрвөн тэрбумын хүчирхийлэл

О.УЯНГА

## ОРОН НУТГИЙН СОНГУУЛЬД ХЭН ЯЛАХ ВЭ

Н.ПУНЦАГБОЛД

Нэг жолоочийг цагдаа зогсоогоод шалгаж л дээ. Гэтэл шаардсан бүхий л зүйл нь байж. Харин замын цагдаа “Бүх жолоочоос түрүүлж шаардсан зүйл бүрдүүлсэн байна” гээд торгочихож. Нэг иймэрхүү наргна саяхан фэйсбүүкээр баахан “давхив”. Замын цагдаагийн газар, Авто тээврийн үндэсний төвтэй хамтран улсын хэмжээнд явуулж буй автомашинууд стандартын шаардлага хангаж байгаа эсэхийг өнгөрөгч наймдугаар сарын 29-ний өдрөөс шалгаж эхэлсэн дээ. Стандартын шаардлага гэдэг нь бас их ёжтой. Автомашинь онго үзэмж, бүрэн бүтэн байдал, салхины шил цуурсан, машины улсын дугаар бүдгэрсэн, гэрэл дохно, цацруулагч байгаа эсэхийг шалгана гэж байгаа.

Үргэлжлэл нь II нүүрт

УИХ-ын ээлжит сонгууль өнгөрсөн зургадугаар сард болж, МАН үнэмлэхүй ялалт байгуулсан билээ. УИХ-ын сонгуультай аймаг, нийслэлийнх ч хамт болж, мөн Ардын нам ялсан. Завхан аймагт АН ялсныг эс тооцвол. Тэгвэл ирэх аравдугаар сард орон нутгийн сонгууль болно. Сум, дүүргийн сонгууль гэсэн үг. Одооноос улс төрийн хүчнүүд бэлтгэлээ базааж, өөр өөрсдийн “сум”-аа тавьж эхэллээ. Харин УИХ-ын сонгуульд үнэмлэхүй ялалт байгуулж чадсан МАН энэ удаад яах бол. Ялж дангаараа шат шатанд төр барих уу. Ялагдсан АН-д иргэд итгэл хүлээлгэж, МАН-д хяналт тавих даалгавар өгөх үү, эсвэл... Орон нутгийн сонгуульд хэний “морь” түрүүлэх бол гэж хүн бүр биенээсээ асууж байна. Харин таах арга алга, ард түмэн хэнийг сонгохыг.



МАН нэрээ барж дууслаа

Яг үнэндээ муулах гэж муу хэлж байгаа юм биш шүү. Иргэд 2016 оны сонгуулийн үеэр улс орныг МАН л аварч чадах нь,

манйгаа өөд нь татна гэж бодож сонголтоо хийх шиг болсон. Гэвч эрх баригчид Засгийн газраа байгуулж, сайд нараа томилж эхлэхэд л олон хүн молигдуулснаа ойлгож, толгойгоо шаяж эхэлсэн байх. Юун мөргөжлийн Засгийн газар,

ёстой хол зөрөх нь тэр. Дараа нь яав. Мөрийн хөтөлбөртөө тусгасан бүхнийхээ эсрэг баахан дүрэм, журам, хууль гаргана гэж дөвчигнөсөн. Өнөөдөр гэхэд л хүүхдийн мөнгийг хасна гээд л байж байна. 60 хувийнх нь мөнгийг өгөөд, үлдсэн 40 хувийг

нь дараа хүүтэй өгнө ч гэх шиг. Энэ мэтээр “үлгэр хүүрнэж” байхад 7, 8, 9 дүгээр сарын мөнгө нь хаана ч байгаа юм, орсонгүй. Сая ээлжит бус чуулган зарлаж, эрх баригчид нэлээд хэд хоног шонө оройгүй л хуралдав.

Үргэлжлэл нь III нүүрт

### “ШИНЭ ТӨГӨЛ” ЦЭЦЭРЛЭГТ ТАВТАЙ МОРИЛ

Олон Улсын стандартад нийцсэн “Шинэ төгөл” цэцэрлэг “Маршал таун” хотхонд нээгдэж, 2016-2017 оны хичээлийн шинэ жилийн элсэлтээ авч эхэллээ. “Шинэ төгөл” цэцэрлэг нь нийслэлийн хамгийн цэвэр агаартай бүсэд өөрийн зориулалтын, бие даасан байрандаа танай хүүхдийг эрүүл, аюулгүй орчинд сургахын зэрэгцээ зөв монгол иргэн болж төлөвшихөд бэлтгэнэ.

**АНГИ БҮРИЙГ КАМЕРЖУУЛСАН ТУЛ ТА ХҮҮХДЭЭ АЖИЛ БОЛОН ГЭРЭЭСЭЭ ХЯНАХ БОЛОМЖТОЙ.**

Нэг ангид хоёр багштай ба анги дүүргэлт 15-20 хүүхэдтэй. Манай цэцэрлэг нь пластик ширээ, сандал, тавилга, тоглоомоос татгалзаж хүүхдийн эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй, байгалийн гаралтай цэцэрлэгийн стандартыг бүрэн хангасан модон ширээ, сандал, тавилгатайгаас гадна АНУ болон Европын сэтгэхүй хөгжүүлэх, сэдэвт, тоо тооллын, бие бялдар хөгжүүлэх тоглоом мөн Японы сургалтын хэрэглэгдэхүүнтэй. Сургалтын хөтөлбөрийн хувьд сургуулийн өмнөх боловсролын ЦӨМ хөтөлбөрийг The Academy of English - ийн JOLLY KIDS 4-5 настай хүүхдэд зориулсан Англи хэлний сургалттай хослуулан хэрэгжүүлж байгаагаараа онцлог юм.

Сургалтаараа хүүхдийг амьдрах ухаан, хэл яриа, тоо тоолол, ёс заншил, урлаг соёл, байгаль болон хүрээлэн буй орчныг танин мэдэхэд сургахаас гадна хүүхдийн биеэ даах, аливаа асуудлыг өөрөө шийдэх, нийгэмших, баг хамт олноор ажиллах, бүтээлч чадварыг хөгжүүлнэ.

Түүнчлэн манай чадварлаг тогооч нарын бэлтгэсэн хоол нь зөвхөн хүүхдэд зориулсан байдаг төдийгүй байгалийн органик гаралтай, амин дэм, витаминээр баялаг, өөх тос багатай, шарж хуураагүй байдгаараа давуу талтай юм. Үүнээс гадна манай гал тогоо нь өндөр зэрэглэлийн Европын техник төхөөрөмжтэй тул хүүхдийн эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй юм.

**ТАНЫ БЯЦХАН ҮРС ЗӨВ МОНГОЛ ХҮН БОЛНО**  
Холбоо барих утас: 99094864

### Ц.ӨНӨРБАЯН: Өөрийн сургалтын эрдмээ 45 жил шавь нартаа түгээж явна

Манай булангийн маань нэр “Чухал хүн”. Тиймээс таны өсч төрсөн нутаг, ээж аав, бага насны он жилүүдийн талаар ярилцлагаа эхлээ?

Монголын баруун хязгаар Увс аймгийн Хяргас сумын уугуул. Миний эцэг, эх Хяргас сумын нутагт төрж өссөн Баяд удмын жирийн малчин ард байсан. Насаараа мал маллаж, 11 хүүхэд төрүүлж өсгөсний хамгийн ахмад нь би.

Үргэлжлэл нь VI-VII нүүрт

## МОНГОЛЫН МЭДЭЭ

Манай сонины IV улирлын захиалга үргэлжилж байна

Улиралд **64** дугаар

**ЗАХИАЛГЫН ҮНЭ 18000**

Монгол шуудан: 70078977  
УБ шуудан: 70127027  
Скай пост: 70121294  
Түгээмэл шуудан: 70115025

| ХААН Банк |         |         |       | Хугалгаа хөгжлийн банк |         |           |         |         |
|-----------|---------|---------|-------|------------------------|---------|-----------|---------|---------|
|           | Авах    | Зарах   |       | Авах                   | Зарах   |           | Авах    | Зарах   |
| АМ.ДОЛЛАР | 2237.00 | 2250.00 | ФУНТ  | 2909.00                | 2995.00 | АМ.ДОЛЛАР | 2237.00 | 2250.00 |
| ЕВРО      | 2478.00 | 2556.00 | РУБЛЬ | 33.10                  | 35.80   | ЕВРО      | 2484.00 | 2560.00 |
| ИЕН       | 21.51   | 22.03   | ЮАНЬ  | 334.90                 | 337.50  | ИЕН       | 21.47   | 22.20   |
|           |         |         |       |                        |         | ФУНТ      | 2921.00 | 3009.00 |
|           |         |         |       |                        |         | РУБЛЬ     | 33.28   | 36.28   |
|           |         |         |       |                        |         | ЮАНЬ      | 334.50  | 338.40  |

УЛС ТӨР

ДУУЛИАНЫ ЭРГЭН ТОЙРОНД

Д.СОСОРБАРАМ: КОМУНИСТУУД ТӨРИЙН ТОЛГОЙД ГАРАХААРАА Л ХҮНД ЯЛ ТУЛГАЖ, АЖЛАА БҮТЭЭДЭГ АРАНШИНТАЙ

Ж.ОТГОН

Нийслэлийн ардчилсан намын дарга Э.Бат-Үүлийг С.Зориг агсны хэрэгт яллагдагчаар татсаныг эсэргүүцэж, Соёлын гавьяат зүтгэлтэн С.Амарсанаа, С.Батчулуун, МУГЖ Д.Сосорбарам тэргүүтэй Ардчилсан хувьсгалын зүтгэлтнүүд хэвлэлийн бага хурал хийлээ. Коммунист угшилтай МАН-ынхан Засгийн эрхэнд гарах бүртгээ энэ хэргийг улс төрийн бусармаг зорилгоор ашиглаж байна гэдгийг тэд хэлэв. Мөн "Монголын төлөө бид хэрэлддэг байсан. Харин хувийн асуудал ерөөсөө байгаагүй. Ажил тарвал хүний ёсоор тэврэлдэж, жаргал зовлонгоо хуваалцаад явдаг байсан. Тухайн үед Э.Бат-Үүл, С.Зориг нар хоорондоо эв түнжин муутай мэтээр ярьж байгаа үлээлт итгэж болохгүй" гэв. МУГЖ Д.Сосорбарам "Ингэж хүнийг гүтгэж болдог юм байна. Төр гүжирдлэгээ биелүүлдэг юм байна. Хүчээр хүнд хэрэг ял тулгаж, ажлаа бүтээдэг араншин тогтчихсон юм байна. Анзаарч байхад коммунистууд төрийн толгойд гарахаараа л ийм юм хийдэг. 2000 онд ч хийж байсан. Одоо энэ жил хийж байна. Энэ үйлдлийг нь таслан зогсоох цаг болжээ. Бид жинхэнэ хүний эрхийг дээдэлсэн нийгэм байгуулж, хараахан амжаагүй юм байна. Тиймээс энэ хуулийн тогтолцоонд шинэчлэл даруй хийхгүй бол болохгүй. Учир нь хууль бусаар хүнд ханддаг. Хууль зөрчиж, нэг үйлдэл дээр хоёр дахин хачин арга хэмжээ авдаг болчихсон байна. Хууль нь болохоор нөгөө хуучин аргаараа ямар ч гэм



Гэрэл зургийн Г.АРГУУЖИН

эмгүй хүнийг гүтгэж, хорнод, нэр төрийг нь гутгаачихаад, тулгаж ял хүлээлгэдэг. Тулгаж ял хүлээлгэсэнээс болоод үе удмаараа хүмүүсийн нэр төр хохирдог. Ийм бусармаг үйл явдалтай би хэзээ ч эвлэрэхгүй. Бид бүгд хүний эрхийн төлөө 1990 онд л ухас хийсэн хүмүүс. Эргээд бодож байхад 1996-2000 оны хооронд хүмүүс овоо эрх дархаа эдэлж байсан юм байна. Түүнээс хойш хүний эрх бүр бүрхэг болсон. Тиймээс одоо шинэ сэргээгээр хандаж, энэ бугширсан байдлаас ангижрах хувьсгал хийх цаг нь болжээ. Ялангуяа хууль хяналтын байгууллагынхан чадамж, сэтгэлгээ муутай хуучин арга барилдаараа байна. Б.Булганыг яаж тамласан гэдгийг бид таашгүй. Тамлаж байгаад "Чи тэрийг зүйгээр л заачих.

Тэгээд л чи сайхан амьдарна" гэсэн олхонгүй арга барилаар ажиллаж байна. Тиймээс би ийм байдалтай нийлэхгүй. Энэ өдрөөс хойш дуугүй байхгүй. Энэ бүхнийг ардчилал, эрх чөлөөг авч ирсний, Улаанбаатар хотыг дөрвөхон жилийн дотор өнгөтэй нөхдүүд болгосны төлөө Э.Бат-Үүлийг шагнаж байгаа шагнал гэж ойлгох уу. Энэ үйл явдлыг өнөөдөр төрж барьж байгаа нөхдүүд буюу УИХ, Засгийн гэрээ нь мэдээгүй байна гэж байхгүй. Харин "Өө телевиз үзэж мэдлээ" гээд хэнэггүй царайлаад сууж хувьсгал байх гэж би бодож байна. Өнөөдөр мэдэгдэл гаргаж байна. Миний хувьд хууль хяналтын байгууллагынханд мэдэгдлээс гадна шаардлага хүргүүлэнэ. Нэн ялангуяа Монгол Улсын ардчилал буюу хүний эрхийг хамгаална гэж ярьж гарч ирсэн,

ярьдаг, хэрэгжүүлэх гэж зүтгэдэг Ерөнхийлөгчид бид хандана. Бүр хатуу шаардлага хүргүүлэнэ. Ардчиллыг бид цуг эхлүүлсэн. Тиймээс ардчиллыг дэмждэг, өөрийнхөө эрх ашгийг дээдэлдэг хүн бүр өөртөө үнэ цэнийг өгч үнэний төлөө яваач гэж уриалмаар байна. Миний эсрэг хэдэн зуун хүн байсан ч үнэний төлөө гав ганцаараа зогсоход ч бэлэн. Ардчиллыг бий болгосон хүмүүсийг гүтгэж эхэлж байгаа нь ардчиллыг байхгүй болгох гэсэн санаа. С.Зоригийн алагад дөрөөлж 2000 онд том ялалт хутгаж хаяаад, энгийн иргэд рүү буу шагайж байна гэж л харагдаж байна. Тиймээс иргэд рүүгээ буу шагайлахгүй ээ. Намайг галзуу,

солиотой, өвчтэй гээд юу ч гэж хэлсэн бай хамаагүй. Би хэнээс ч айхгүй. Энэ толгой мөрөн дээрээ байгаа цагт энэ үйл хэргээ хэзээ ч зогсоохгүй. Би амьд байгаа шүү гэдгийг хэлье" гэлээ.

"Бид нэг хөдөлвөл яг л 1990 оных шиг ээ хөдлөх болно"

Харин АН-ын анхдагч гишүүн С.Батчулуун "С.Зоригийн хэрэг С.Зоригийн хэрэг биш боллоо. Уг нь бид энэ хэргийг илрэх байх гэж их хүлээсэн. Гэтэл одоо С.Зориг ч, хэргийг илрүүлэх нь ч гол асуудал биш болчихжээ. Харин С.Зоригийн хэрэг гэдэг маань улс төрийн хамгийн хар үйлсийг бүтээхэд ашигладаг хэрэглүүр болчихлоо. Ийм зүйл рүү ард түмнийг мансууруулаад, дагуулаад оруулчихлаа. Өөрөөр хэлбэл, одоо энэ хүмүүст С.Зориг чухал биш. Харин С.Зоригийн хэргээр хэнийг алах вэ гэдэг нь чухал болсон байна. Бид үүнийг тэвчиж чадахгүй. Тэр хүн ийм зүйлийн эсрэг байсан учир хөнөөгдсөн. Би С.Зориг, Э.Бат-Үүл хоёртой найман жил ажиллаж байлаа. Тиймээс ч хувийн өс хонзон байгаагүй гэдгийг гэрчилж чадна. Хэрвээ бид нэг хөдөлвөл яг л 1990 оных шиг ээ хөдлөх болно. Учир нь нэг үйл хэргийн төлөө зүтгэж явсан бидний нөхдийн нэгийг нь хутгалж алсан. Харин одоо нөгөөг нь амьдаар нь сүг сүнс болгож гэж байгаа бол хамт олноор нь алаарай. Ардчиллыг дэмждэг мянга мянган хүмүүсийг аваачиж, шоронд хатааж алаарай гэж хэлмээр байна" гэв.

Дугаарын 60 мөр

Дөрвөн тэрбумын хүчирхийлэл

Үргэлжлэл. Түүрүүч нь I нүүрт

За цаашлаад ослын гурвалжин, эмийн сан, гал унтраагч гэх мэт зүйлсийг нарийвчлан шалгаж буй. Дээрээс нь бензин хөдөлгүүртэй машинаас гарч буй утаан дахь хорт бодисын хэмжээ, дизель хөдөлгүүртэй машины утаан дахь тортогжилтыг хэмжиж, иргэдэд 19200-аас 42 мянган төгрөг хүртэл торгууль ногдуулж байгаа юм. Энэ их дайралт эхэлсний дараа л нэг дүргүй нь хүрсэн нөхөр хошигнох, бухимдахын хооронд дээрх ёжлолыг бичихгүй юу. Өнөөдөр Улаанбаатарт цагдаа нар ёстой л баруун солгойгүй торгож байгаа. Энэхүү шалгалт энэ сарын 30-ны өдрийг хүртэл үргэлжлэх ёстой. Тэгэхээр замын цагдаа нар хэн гээч жолоочийг, хаана зогсоогоод, ямар шалтгаанаар торгох нь өөрийн дур. Машинаа угаагаагүй давжиж яваа нөхрийг дохиж зогсоогоод, "өнгө үзэмж муутай тээврийн хэрэгсэлтэй хөдөлгөөнд оролцдоо" гээд л торгоод хаячихна шүү дээ. Бас жаахан утаа хахад байгаа машинтай нөхрийг бол ямар ч өчигтүй торгож болно. Үүнийг чинь "Дөрвөн тэрбумын хүчирхийлэл" гээд байгаа юм. Мань мэт нь ч ингэж хэлээгүй. Бүхэл бүтэн УИХ-ын гишүүн Т.Аюурсайхан энэ мэдээллийг ард түмэнд өгсөн. Угаасаа л төсөв бүрдүүлэхээр торгож байгаа гэдэг нь тодорхой л доо. Өмнө нь хэзээ тэгтлээ эмийн сан, галын хор нэхдэг байлаа даа. За болье, өнгө үзэмжтэй байх ёстой гэж хэн ч торгож байгаагүй юм шүү, харин.

Гэтэл өнөөгийн эрх баригчдын үед л машинаа угааж мөнгөгүй байсныхаа төлөө торгууль мэдэхээр болчихлоо. Ийм л байна. Хэрвээ манай эрх баригчид, тушаал өгөгчид эрхэм жолооч нарыг эмх цэгцэнд нь оруулах гэж байсан бол шууд торгохгүй шүү дээ. Ядаж сарын хугацаа өгнө. За өнөөдрөөс эхлээд нэг сарын хугацаанд жолооч нарыг эмийн сан, галын хор, ослын гурвалжинтай болохыг анхааруулж байна. Мөн автомашины өнгө үзэмждээ анхаарч, цацруулагчтай болох хэрэгтэй. Харин сарын дараагаас шаардлагатай зүйлсийг биелүүлээгүй жолооч нарыг торгоно гэсэн бол арай өөр. Гэтэл шууд нэг журам гаргаад, шалгаад, торгоод эхэлж байгаа байхгүй юу. Харин ямар азаар улсын төсөвт жолооч нарын халааснаас ердөө дөрөвхөн тэрбумыг татна гэсэн төлөвлөгөө гаргасан юм. Энэ мөнгийг бүрдүүлэхийн тулд 100 мянган автомашиныг шалгаж, жолоочийг нь торгоход л босоод ирэх юм уу даа, янз нь. Цаад эрх баригчид чинь хотын биднээсээ дөрвөн тэрбумыг тэр чигээр нь татахгүй юм гэсэн. Уул уурхайнд ажиллаж байгаа том оврын автомашины жолооч нарын халааснаас 2.1 тэрбумыг нь татах сураг байсан. Тэгэхээр нийслэлчүүд бид ердөө л 1.9 тэрбумыг улсынхаа төсөвт хандивлах нь. Эхлээд эмийн сан, галын хор, ослын тэмдэг зарж байгаа нөхдүүдээс бас хөрөнгө оруулалт хийнэ ээ. Энэ журам гарснаас хойш цагдаа нарын шаардаж байгаа бүх зүйлийг багцаар нь зарж байгаа сэргэлэн "толгой"-нууд ч гарч ирсэн байсан. Тэднийгээ жаахан баяжуулаад, дараа нь улсынхаа төсөвт хандиваа өргөхөөс өөр яах вэ. Аз байвал торгуулах 100 мянгад нь багтахгүй ч юм бил үү, тийм биз дээ.

МЭДЭЭЛЭЛ

Д.Ганбат: Транссибирийн төмөр зам нь дамжин өнгөрөх тээврийг хөгжүүлэхэд чухал ач холбогдолтой

"Транссибирийн төмөр замуудын зохицуулах зөвлөл"-ийн 25 дугаар их хурал өчигдөр зохион байгуулагдлаа. Тус хуралд 26 орны 130 төлөөлөгч оролцож буй бөгөөд Монгол Улсын Зам, тээврийн хөгжлийн сайд Д.Ганбат Засгийн газрын бодлого болон транзит тээвэрлэлтийн хөгжлөлтийн асуудлаар илтгэл тавьсан юм. Энэхүү хурал нь Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдоржийн ивээл дор болж буйгаараа онцлог бөгөөд Монгол-Оросын хувь нийлүүлсэн нийгэмлэг УБТЗ бус нутгийн эдийн засгийн оролцоогоо нэмэгдүүлэх, транзит тээврийн урсгалыг эрчимжүүлэх зорилгоор энэхүү хурлыг Монгол Улсад анх удаа зохион байгуулжээ.

Хурлын үеэр Транссибирийн магистраль нь худалдаа бизнесийн харилцааны хуурай замын дэлхийн хэмжээний суваг бөгөөд Ази-

Европын хоорондын ачаа эргэлтийн хамгийн шуурхай, хамгийн дөт замнал гэдгийг Зам, тээврийн хөгжлийн сайд Д.Ганбат онцолж байв. Тэрбээр илтгэлдээ "Трансмонголын төмөр замын коридор нь Транссибирийн төмөр замын нэг салшгүй хэсэг бөгөөд Ази-Европыг холбосон төмөр замын замналудаас хамгийн дөт зам тул ачаа тээврийн урсгалыг аль болох өөрийн улсаар дамжуулан өнгөрүүлэх, бүс нутгийн логистикийн сүлжээнд илүү өргөнөөр хамрагдаж, идэвхитэй оролцох эрмэлзэлтэй байна. Энэхүү зорилгын хүрээнд Монгол Улсын Засгийн газраас өөрийн орны төмөр замын нэвтрүүлэн өнгөрүүлэх чадварыг нэмэгдүүлэх, дамжин өнгөрүүлэх тээвэрлэлтийг оновчтой зохион байгуулах, "Улаанбаатар төмөр зам"-ыг шинэчлэх, БНХАУ, ОХУ-ыг холбосон коридорын тоог нэмэгдүүлэх зэрэг бодлого баримтлан ажиллаж байна" гэв. Ийнхүү Зам,

тээврийн хөгжлийн сайд Транссибирийн төмөр замын коридорын тээврийн үйлчилгээнд оролцож байгаа талуудын хамтын ажиллагааг бэхжүүлэх, шинэ техник технологи нэвтрүүлэх, тээвэрлэлтийг нэмэгдүүлэх, хилийн гарцуудын хүчин чадлыг нэмэгдүүлэх зэрэг үйл ажиллагааг дэмжиж ажиллахаа илэрхийлжээ. УБТЗ Транссибирийн төмөр замыг БНХАУ-ын нутгийн гүнтэй шууд холбож байгаа чухал зам. Энэ төмөр зам 24-25 сая тонн ачаа тээвэрлэх хүчин чадалтай бөгөөд 2016-2017 онд техникийн шинэчлэл хийснээр тээвэрлэлтийн хүчин чадлыг 34 сая тонн хүргэх зорилгыг тавин ажиллаж байгаа аж. Хүчин чадлаа нэмэгдүүлснээр УБТЗ гадны бизнесийн групп болон тээвэр зуучийн байгууллагуудад үйл ажиллагаагаа танилцуулж, ачаа тээвэрлэхийг санал болгох ач холбогдолтой юм.

ММ-ИЙН ТОДРУУЛГА



ЖИРИ КРАТОЧВИЛ: Ачаа тээврийн нэгдсэн бүртгэлтэй болох нь эдийн засгийн хувьд өндөр ач холбогдолтой

"Та бүхэнд мөн энэ өдрийн мэнд хүргэе. "Монгол улсын автотээврийн зохицуулалтын үйл ажиллагааг БНЧУ-ын арга туршлагыг үндэслэн сайжруулах, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг хяналтыг нэмэгдүүлэх" нэртэй энэхүү төсөл нь Монгол Улсын автотээврийн тээвэрлэлт, автозамын сүлжээ, транзит буюу дамжин өнгөрөх тээвэрлэлтийн үйл ажиллагааг боловсронгуй болгохын тулд орчин үеийн техник технологи ашиглан чанар, хүртээмж, хяналт зохицуулалтын механизмыг олон улсын жишигт нийцүүлэхэд БНЧУ-ын туршлага судлах, нэвтрүүлэх зорилготой төсөл юм.

"Төслийн хүрээнд яг ямар ажил хийгдэх вэ? -Бид бүхэн цаашид олон чиглэлээр хамтран ажиллахаар төлөвлөж байна. Үүнд, Монгол Улсын автозамын тээвэрлэлтийн зохицуулалт, зохионбайгуулалтын үйл ажиллагааг сайжруулах, ялангуяа жолоочийн ажил амралтын горимыг хянахад зориулагдсан дижитал тахографийг Монгол Улсын автотээврийн хөдөлгөөнийг хянах үйл ажиллагаанд

нэвтрүүлэх, үүнтэй холбогдуулан Монгол Улсын Засгийн газар, БНЧУ-ын Засгийн газар хоорондын Автотээврийн хэлэлцээр байгуулах талаар хамтарсан ажлын хэсэг байгуулах нөхцлийг судлахаар ажиллаж байна. Мөн Хоёр улсын Элчин сайдын яамдаар дамжуулан Чех улсын ачаа тээврийн салбарт дутагдалтай байгаа хүнд даацын тээврийн хэрэгслийн жолооч нийлүүлэх асуудлыг судлах, цаашлаад Монгол Улсын улс, хот хоорондын зорчигч тээвэрлэлтийн үйлчилгээ эрхлэгч компаниудын парк шинэчлэлтэд зориулан Засгийн газрын хөнгөлөлттэй зээлээр БНЧУ-аас Euro IV стандартын автобус олгох боломж, нөхцлийг судлахаар харилцан тохиролцдоо.

-БНЧУ-ын хувьд яагаад Монгол Улсыг онцлон энэхүү төслийг хэрэгжүүлэх болсон бэ? -Монгол Улс нь өргөн уудам нутагтай, Чех улстай адил далайд гарцгүй орон юм. Үүнтэй уялдаанд тээврийн төрлүүдээс автозамын, төмөр замын, гаадын замын тээвэрлэлт зонхилдог бөгөөд нийт тээврийн 95 хувийг автозамаар тээвэрлэж байгаа юм. Энэ бүхнээс харахад Чех улс Монгол Улсад туршлага судлуулах, хамтран ажиллаж, автотээврийн салбарт дэмжлэг үзүүлэхэд илүү ойр байгаа юм л даа.

**ММ-ИНФО**  
МОНГОЛЫН МЭДЭЭ  
18 дахь жилдээ

Ерөнхий эрхлэгч: **С.ГАНТОГОО**

Орлогч эрхлэгч **Ч.ЧУЛУУНЦЭГ**  
99189158

Хариуцлагатай нарийн бичгийн дарга: **Э.ЭНХЦЭЦЭГ**  
88873012

Ахлах редактор: **Б.ӨНӨРТОГТОХ**  
88006842

Шуурхай мэдээлэл, эрэн сурвалжлах алба **Н.ПУНЦАГБОЛД**  
88096454

Улс төр, гадаад мэдээлэл, эдийн засгийн алба: **Б.ӨНӨРТОГТОХ**  
88006842

Гэрэл зургийн алба: **Г.АРГУУЖИН**  
96017873

Компьютерийн алба: **Б.ГАНЗОРИГ**  
99998796

Маркетинг, зар сурталчлаганы алба: **Н.АЛТАНЦЭЦЭГ**  
99173710

Захиалга, борлуулалтын алба: **М.ДАВААДУЛАМ**  
99042510

**Э.САЙНЗАЯА**  
99197866

Дугаарыг эрхэлсэн **Э.ЭНХЦЭЦЭГ**

Улсын бүртгэлийн дугаар: 907300528  
Индекс: 100757

Редакцийн хаяг: Улаанбаатар хот. Сүхбаатар дүүрэг. Чөлөөт хэвлэл сан /Хэвлэлийн хүрээлэн/, 2 давхар. 209, 211 тоот

Харилцах утас, факс: 976-70113551

"Монголын мэдээ" сонины редакцияг эхийг бэлтгэж, "Чөлөөт хэвлэл сан"-ийн хэвлэх үйлдвэрт хэвлэв.

"Монгол Улсын автотээврийн зохицуулалтын үйл ажиллагааг БНЧУ-ын арга туршлагыг үндэслэн сайжруулах, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг хяналтыг нэмэгдүүлэх" төслийг хамтран хэрэгжүүлэхээр БНЧУ-аас автотээврийн салбарын төлөөлөгчид 2016 оны есдүгээр сарын 05-11-ний өдрүүдэд Монгол Улсад хүрэлцэн ирсэн билээ. Тус төслийн ахлагч болох Жири Краточвилтай уулзаж, ярилцлаа.

-Юуны өмнө БНЧУ болон Монгол Улс хооронд хэрэгжүүлж буй энэхүү төслийн талаар танилцуулахгүй юу?

# ҮЗЭЛ БОДОЛ

ӨНӨӨДРИЙН ТОП ИШЛЭЛ



ᠨᠢᠶᠦᠵᠢᠨ ᠶ᠋ᠢᠨ ᠲᠣᠮᠤ ᠨᠢᠨᠢ  
ᠠᠵᠤᠯᠠᠭᠤ ᠶ᠋ᠵᠢᠨ, ᠲᠦᠵᠡᠨ ᠶ᠋ᠵᠢᠨ  
ᠠᠠᠭᠤᠯᠠ. ᠠᠠᠠᠠᠠᠠ ᠠᠠᠠᠠᠠᠠ  
ᠲᠠᠠᠠ ᠠᠠᠠᠠᠠᠠ ᠨᠢᠶᠦᠵᠢᠨ  
ᠠᠵᠤᠯᠠᠭᠤ ᠲᠦᠵᠡᠨ ᠠᠠᠠᠠᠠᠠ ᠲᠦᠵᠡᠨ  
ᠠᠠᠠᠠᠠᠠᠠ ᠠᠠᠠᠠᠠᠠ ᠠᠠᠠᠠᠠᠠ  
ᠠᠠᠠᠠᠠᠠ ᠠᠠᠠᠠᠠᠠ ᠠᠠᠠᠠᠠᠠ  
ᠠᠠᠠᠠᠠᠠ ᠠᠠᠠᠠᠠᠠ ᠠᠠᠠᠠᠠᠠ  
ᠠᠠᠠᠠᠠᠠ.

Монголын Нэгдсэн Үндэстний Холбооны Ерөнхийлөгч  
Х.Баттулга

Гэрэл зурагийг Г.АРГУУЖИН

ҮЗЭД БОДОЛ

# ОРОН НУТГИЙН СОНГУУЛЬД ХЭН ЯЛАХ ВЭ



Гэрэл зурагийг Г.АРГУУЖИН

Үргэлжлэл.  
Түрүүч нь I нүүрт

Тэгэхдээ юу амжуулав. Төсвийн тодотгол гэгчээ батлах шиг боллоо. Уг нь төсвөө хэмнэнэ, бүсээ чангална, дарга нараасаа хэмнэлтээ эхэлнэ гээд л байсан. Сардаа 20, 30 саяын цалинтай нөхдүүдийн халаас руу өнгийхөөр болсон ч чадсангүй.

Баячуудын татварыг нэмж, хадгаламжийн хүүнээс татвар авна ч гэж ярьсан, бас л зориглосонгүй. Баян, эрх мэдэлтэй хүмүүс рүүгээ халдаж чадахгүй салганаж байгаад сүүлдээ дундаж руугаа, бүр ядуус руу дайрсан. Төрийн албан хаагчдын 36 сар хүртэлх тэтгэмжийг танана гэж баахан айлгаж байгаад, сүүлдээ өөрсдөө айгаад болив. Аргагүй шүү дээ, эмч, багш нар ажил

Тийм болохоор хамгийн хүчтэй өрсөлдөгч болох АН-ын рейтинг нөгөө талдаа өсч таарна биз дээ. Гэвч өнөөдөр АН-ынхан ҮЗХ-ны хурлаа хийж чадаагүй байгаа. Баахан шинэчлэл ярьсан хүмүүс л, сонгуулийн ялагдлын буруугаа тохох хүн хайгаад л. Намын даргаа ч сонгож чадаагүй байгаа шүү дээ. Нийслэлийн намын асуудал ч бас эвгүй л байгаа. Нийслэлийн сонгуульд ялагдсан хариуцлагаа хүлээж Э.Баг-Үүл дарга ажлаа өгнө гэж байсан. Харин гишүүд нь түүнийг орон нутгийн сонгуульд намаа ахлаж орохыг гуйсан гэх. Гэтэл бас л өнөөх алдарт хэрэгтэй холбогдуулчихлаа. Дээрээс нь АН-ын нэр дэвшигчдийг зарим суманд бүр бөөнөөр нь хасаад хаячихсан тохиолдол ч гарсан. Одоо угаасаа УИХ, нийслэл, аймагт МАН эз дийлж юу эсийг хийнэ. АН-ын зүгээс шүүхэд хандана, энэ тэр гэж гоншигноод ч тус болохгүй. МАН-ын рейтинг буурч, иргэдийн итгэл алдарч байгаа ч тэд өрсөлдөгчдөө сонгуульд оролцуулахгүй байгаад ч хамаагүй ялах гэж улайрч таарна. Тийм болохоор АН орон нутгийн сонгуулийн өмнө хурал хуйгаа хийгээд, дарга нараа солиод, шинэ эрч хүчтэйгээр дайралт хийх байх. Үгүй бол дээр дооргүй дөрвөн жил лааз өшиглөх нь тодорхой.

Гуравдагч хүчингүй орон нутгийн сонгууль

Өнгөрсөн зургадугаар сард болсон сонгуулиар нэг хэсэг хүчтэй гарч ирмээр шинжтэй байсан гуравдагч хүчин ор мөргүй арчууллаа. МАХН ч гэсэн арчуулаад л дууссан. Бие даагчдыг 2012 онд хэд хэдээр нь сонгож байсан иргэд 2016 онд итгэл үзүүлсэнгүй. Угаасаа бие даагчид нь өнгөрсөн дөрвөн жил товчлуураа үнэлэхээс өөр юм хийгээгүй болохоор тэр биз. Зөвхөн УИХ-ын сонгууль гэлтгүй аймаг, нийслэлд ч

гуравдагч хүчин болоод бие даагчид үсгүй арчуулсан шүү дээ. Тийм болохоор орон нутгийн сонгуульд ч гэсэн тэдэнд найдлага байхгүй. Яах вэ, МАХН нэр дэвшигчдээ илгээх л байх. МАН-ын нэр хүнд унасан, АН ороо бусгаа байгаа энэ үед жаахан найдлага байхыг үгүйсгэх аргагүй.

МАХН-ынхан ч ингэж л найдаж байгаа байх. Даанч тэдэнд сум, дүүрэгт очих боловсон хүчин байхгүй. Бие даагчдад бол боломж байхгүй. Дээр өгүүлсэн. Өчигдөр гэхэд л Баянзүрх дүүрэгт бие даан нэр дэвшсэн 30 гаруй хүнийг сонгуульд өрсөлдөх эрхгүй болгосон талаар гомдоллоод л байна билээ. Энэ мэтээр хавчлага ч бас явж байна. Ер нь орон нутгийн сонгуулийн өмнө ийм л нэг бүрхэг байдал үүсчихлээ. Гэхдээ 60 чавганц уралдвал нэг нь түрүүдгийн үлгэрээр хэдэн хүн сонгогдох нь л сонгогдоно. Тэр нь хэн бэ гэдгийг бид таашгүй.

...Ер нь орон нутгийн сонгуулийн өмнө ийм л нэг бүрхэг байдал үүсчихлээ. Гэхдээ 60 чавганц уралдвал нэг нь түрүүдгийн үлгэрээр хэдэн хүн сонгогдох нь л сонгогдоно. Тэр нь хэн бэ гэдгийг бид таашгүй...

хаячихвал энэ улс чинь баларна биз дээ. Ингээд л эцсийн дүндээ машинтай иргэдийн халаасыг сэгсэрч, дөрвөн тэрбумыг босгохоор болоод л дууслаа. Өөр юу ч шийдэж чадсангүй, энэ засаг. Юу ч хийгээгүй гэхэд бас хэцүү л дээ. Ядаж өрөө тасалгаага сайхан болгосон. Бас ч гэж хэдэн хуулийн төслийн нэрийг өөрчилж, Гэр бүлийн хүчирхийллийн хуулийг үгүй хийсэн юм байна. Ингэж ажиллаж байгаа МАН-ыг одоо сонгох уу. Ард түмнээ сайхан амьдруулна, бүх зүйлийг өөд нь татна гээд байсан эрх баригчид одоо болохоор “бүсээ чангал”, “Ард түмэн хэтэрхий тансаг байна”, “Иргэд тансаглалд автчихаж” гэх маягийн юм яриад байж байна. Өнөөдөр ярьсан зүйлээ маргааш нь үгүйсгээд л хоёр сарыг үдэв. Ерөнхийдөө МАН нэрээ барж дуусч байгаа. Ийм байхад МАН ялна гэж хэлэхэд хэцүүхэн л байна.

АН-д боломж байгаа, гэвч...

АН-д ялах боломж байгаа гэж харах хүн олон байна. МАН төрд гараад, ард түмэнд таалагдсан бил үү, үгүй. Уг нь ард түмэнд таалагдах гэж гаргасан шийдвэрүүдээсээ ухарсан. Гэхдээ л эргэж буцсан, салж нийлдэг эхнэр нөхөр шиг үйлдлүүд нь тэднийг орон нутгийн сонгуулийн өмнө рейтингээ алдахад хүргэсэн.

 **ХААН БАНК**

**СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН УРИЛГА**

Сонгон шалгаруулалт зарласан огноо: 2016.09.14

**ДОХИОЛОЛ ХАМГААЛАЛТЫН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ БЭЛТГЭН НИЙЛҮҮЛЖ, СИСТЕМИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХАНГАН ХАМТРАН АЖИЛЛАХ КОМПАНИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ**

ХААН Банкны орон нутгийн салбар нэгжид ашиглагдах дохиоллын тоног төхөөрөмж бэлтгэн нийлүүлж, суурилуулах, дохиоллын системийн үйл ажиллагааг 24 цагийн турш хянаж мэдээ дамжуулах гэрээт компанийг сонгон шалгаруулах тул энэ чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг туршлагатай байгууллага, аж ахуйн нэгжийг сонгон шалгаруулалтад оролцохыг урьж байна.

Сонгон шалгаруулалтад оролцох хүсэлтэй байгууллагууд ХААН Банкны 50000045060000035 тоот дансанд 50,000 төгрөгийг эргэн төлөгдөхгүй нөхцөлтэй тушааж, баримтыг оролцох хүсэлтийн албан бичгийн хамт Төв ХААН Банкны ресепшинд өгч, сонгон шалгаруулалтын өгөгдлийг авна уу.

Материалыг 2016 оны 09 дугаар сарын 28-ны өдрийн 12:00 цаг хүртэл Төв ХААН Банкны ресепшин хүлээн авах ба зөвхөн шалгарсан компани, аж ахуйн нэгжид бичгээр хариу мэдэгдэнэ.

Хаяг: Сүхбаатар дүүрэг, 4-р хороо, Сөүлийн гудамж-25, ш/х-192 Улаанбаатар 14250

Сонгон шалгаруулалттай холбоотой мэдээллийг procurement2016@khanbank.com хаягт хандаж авна уу.

 Харилцагчийн мэдээллийн төв 1800-1917 | www.khanbank.com | khanbank.com/facebook | khanbank.com/twitter

ДЭЛХИЙ

НҮБ-ын 71 дэх ерөнхий ассамблейн хуралдаан эхлэв

АНУ-ын Нью-Йорк хотод НҮБ-ын 71 дэх ерөнхий ассамблей хуралдаж эхэллээ. Энэ удаагийн хуралд дэлхийн 193 орны төлөөлөгчид оролцож байгаа бол хурлын даргаар саяхан энэ хариуцлагатай ажлыг хүлээн авсан Фижи арлын дипломатч асан Петер Томпсон ажиллаж байна. Нэгдсэн ассамблейн чуулга уулзалтыг нээж НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга Бан Ги Мун үг хэлжээ. Тэрбээр дэлхийн олон орны удирдагчдад хандан шударга бус байдалтай хэзээ ч эвлэрэхгүй байхыг уриалаад байгалийн болон бусад аюул заналхийлэлд өртсөн орнуудад тусламжийн гараа сунгаж байх хэрэгтэйг санууллаа. Чуулга уулзалтын хөтөлбөрийн дагуу энэ сарын 20-ны өдөр дэлхийн тэргүүлэх орны удирдагчид олон улсад тулгамдаад байгаа асуудлуудыг хөндөх юм байна. Энэ өдөр үг хэлэх АНУ-ын Ерөнхийлөгч Барак Обама Европ тивийг дараад байгаа цагаач, дүрвэгчдийн асуудлыг хөндөх төлөвтэй байна. Харин Их Британийн шинэхэн Ерөнхий сайд Тереза Мей Европын холбооны аюулгүй байдал, бүс нутгийн тогтвортой хөгжлийн талаар өөрийн үзэл бодлоо илэрхийлэх магадлал өндөр байгаа юм. Ерөнхий ассамблейн сайд нарын түвшний уулзалтаар Сирийн хямралыг энхийн арга замаар шийдвэрлэх асуудлыг ярилцахаар төлөвлөж байна. Энэ удаагийн чуулга уулзалтаар цаг үетэй холбоотой нэгэн чухал асуудлыг хэлэлцэх шаардлага гарсан гэдгийг уулзалтыг зохион байгуулагчид онцоллоо. Умард Солонгос улс саяхан цөмийн туршилт амжилттай хийж гүйцэтгэсэн нь олон улсын хүчтэй эсэргүүцэлтэй тулгараад байгаа. Зүүн Азийн бүс нутгийн аюулгүй байдалд заналхийлсэн Пхеньяны энэ алхмыг дэлхий нийтээрээ хэлэлцэж, зохих хариуг барих хэрэгтэй гэдэгт цөөнгүй улс орон санал нийлжээ. Энэ удаагийн Ерөнхий ассамблейд Умард Солонгосын талаас Гадаад хэргийн сайд Ри Бонг Хо оролцож байна.



ХИЛЛАРИ КЛИНТОН СОНГУУЛИЙГ ОРХИХ УУ

БДАВААХҮҮ

АНУ-ын төрийн тэргүүн Барак Обамагийн бүрэн эрхийн хугацаа ирэх оны нэгдүгээр сард дуусч, тэрбээр арваннэгдүгээр сард болох Ерөнхийлөгчийн сонгуульд ялалт байгуулсан эрхэмд үүрэгт албаа хүлээлгэн өгөх учиртай. Одоогоор АНУ-ын дараагийн Ерөнхийлөгчийг сонгох сонгуульд Ардчилсан намаас төрийн нарийн бичгийн дарга асан Хиллари Клинтон, Бүгд найрамдах намаас үл хөдлөх хөрөнгийн тэрбумтан Доналд Трамп нар нэр дэвшин өрсөлдөж байгаа юм. Хамгийн сүүлд явуулсан оlnыг хамарсан судалгааны дүнгээс харахад, Хиллари Клинтон олонхийн дэмжлэгийг хүлээгээд буй. Харин "Мексик АНУ-ын хилд битонон хана босгоно", "Лалын шашинтнуудыг хил нэвтрүүлэхгүй", "Хууль бус цагаачдыг нутаг буцаана" гэх зэргээр ширүүхэн мэдэгдлийг хийж, олны дургүйцлийг төрүүлсэн Доналд Трампын дэмжигчдийн хувьд өмнөхөөсөө унасан

үүзлэлттэй байгаа. Гэвч сүүлийн үед тус улсын нэртэй эмэгтэй улстөрч болох Хиллари Клинтон эрүүл мэндийн байдал америкчуудын санааг зовоох болсон юм. Улмаар энэ сарын 11-нд болсон 2011 оны терроризмын гашуудлын үйл ажиллагааны үеэр тэрбээр уушигны хатгалгаа туссаыг эмч нь баталсан байдаг. Тэгвэл энэхүү явдлыг өрсөлдөгч нь өлгөн авч, "Клинтон эрүүл мэндийн шалтгааны улмаас Нью Йорк мужийн Чаппак дахь гэртээ эмчилгээ хийлгэж буй бөгөөд тэрбээр энэ сарын 12, 13-ны өдөр Калифорнид

үүний улмаас олон улсын зарим эх сурвалж Хиллари Ерөнхийлөгчийн сонгуулийг орхих эсэх талаарх таамгийг аль хэдийнэ дэвшүүлж эхлэв. Хэрэв Ардчилсан нам АНУ-ын Ерөнхийлөгчийн сонгуулиас нэр дэвшигчээр буцаан татвал, оронд нь хэнийг нэр дэвшүүлэх вэ. Энэ асуулт олны анхаарлыг хамгийн их татаж байна. Эдүгээ 68 настай нэр дэвшигч Хиллари Клинтон эрүүл мэндийн шалтгааны улмаас Нью Йорк мужийн Чаппак дахь гэртээ эмчилгээ хийлгэж буй бөгөөд тэрбээр энэ сарын 12, 13-ны өдөр Калифорнид

болох уулзалтуудаа цуцалсан. Энэ явдал эмэгтэй улстөрчийг сонгуулийн тулаанаас гарах таамгийг бүр лавшруулж орхив. АНУ-ын Үндсэн хуульд Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшиж буй эрхэм ямар тохиолдолд нэрээ татаж болох талаар тодорхой зүйл тусгагдаагүй ч, тухайн намын дүрэмд тусгасан байдаг ажээ. Ардчилсан намын дүрмийн хоёрдугаар зүйлийн долоод, "Ардчилсан намын Үндэсний зөвлөлдөх хорооны дарга нэр дэвшигчийн сул орон тоог нөхөх зорилгоор шуурхай хуралдааныг нээнэ" гэж заажээ. Бүгд найрамдах намын дүрэмд ч ийм заалт байдаг юм байна. Ардчилсан намын тусгай хуралдаанд хамгийн их дэмжлэг авсан эрхэм хоосон орон тоонд нэр дэвших учиртай юм байна. Гэхдээ өмнөх сонгуульд ийм тохиолдол гарч байгаагүй гэнэ. Ямартай ч, одоогийн нөхцөлд Хиллари Клинтон эрүүл мэндийн шалтгааны улмаас сонгуулийн тулаанаас нэрээ татах магадлал тун өндөр байгаа бөгөөд зарим ажиглагчид аль хэдийнэ түүний оронд нэр дэвших эрхэм хэн байхыг таамаглаж эхэлсэн байна. Тэдний нэрлэж буйгаар хамгийн боломжит хэд хэдэн хувилбар бий аж. Үүнд, сенатч Тим Каине, нам доторх сунгаанд өрсөлдсөн сенатч Берни Сандерс, одоогийн дэд Ерөнхийлөгч Иосеф Байден нарын нэр багтжээ. Одоогоор нөхцөл байдлыг тааварлахад бэрх байгаа ч, Хиллари эрүүл мэндийн шалтгааны улмаас нэрээ татвал Ардчилсан намаас өөр хүн нэр дэвших бололтой.

Оросын нийт сонгогчдын 0.05 хувь нь саналаа өгчээ

ОХУ-ын нийт сонгогчдын 0.05 хувь нь Төрийн Думын сонгуульд саналаа урьдчилан өгсөн тухай тус улсын Сонгуулийн Төв комиссын дарга Элла Памфилова өчигдөр мэдэгдлээ. Өчигдрийн байдлаар нийт сонгогчдын 0.05 хувь нь буюу 63766 хүн саналаа урьдчилж өгчээ. Саналаа өгсөн хүмүүсийн ихэнхи нь аялагдсан болон хүрч очиход бэрх бүс нутгийн иргэд байжээ. Түүнээс гадна, үерт нэрвэгдээд буй Приморийн хязгаарын найман бүсэд оршин суугаа 20 мянга орчим иргэд өнөөдөр саналаа урьдчилан

өгөх юм байна. Тэрбээр цааш нь хэлэхдээ, ажиглагчдыг бүртгэх хугацаа өчигдрөөр дуусгавар болж байгаа улс төрийн намуудад сангуулсан байна. ОХУ-ын Төрийн Думын ээлжит сонгууль холимог тогтоолцоогоор ирэх нам гарат болох бөгөөд 225 депутатыг намын жагсаалтаар, 225 депутатыг нэг мандаттай тойргуудаас сонгох ажээ. Мөн өдөр тус улсын 39 бүс нутагт орон нутгийн хурлын сонгууль болох бол холбооны долоон субъектэд удирдах албан тушаалтнуудыг шууд сонгох сонгууль болно.

Лалын шашинт эмэгтэйг шатаахыг завджээ

АНУ-ын Нью Йорк мужийн Манхаттан хотын тавдугаар гудамжинд байрлах тансаг зэрэглэлийн гоо сайхны төвийн өмнө нэгэн ноцтой хэрэг гарчээ. Гивлүүр өмсч нүүрээ халхалсан эмэгтэйг тухайн хэсэгт явж байхад нь нэгэн этгээд гэнэт хувцсанд нь гал тавьж, амьдаар нь шатаахыг завдсан байна. Одоогоор цагдаагийн байгууллага хэргийн газрын хяналтын камерын бичлэгийн дагуу хэрэгтнийг эрэн сурвалжилж эхэлжээ. Хохиругч эмэгтэйн мэдүүлснээр түүнийг гудамжаар алхаж байтал гэнэт л хувцас нь шатаж эхэлсэн байна. Хуулийнхан энэ удаагийн хэргийг лалын шашинтнуудыг үзэн ядагчид үйлдсэн хэмээн үзэж, шалгалтын ажлыг эхлүүлж, хотын иргэдийг тусалж дэмжихийг уриалжээ. Лалын шашинтнууд барууны орнуудад терроризмын хэрэг үйлдэх болсонтой холбоотойгоор америкт мөн шашныг үзэн ядах үзэл суртал хүчтэй дэлгэрэх болсон байна.



Францын өмнө Марселлд зангуугаа хаян зогсч буй дэлхийн хамгийн том "Harmony of the Seas" хөлөгт зорчигч тээвэрлэх сургуулиг хийгдэж, энэ үеэр аврах завь далай руу унан хүний амь нас хохирчээ. Тодруулбал, хөлгийн багийн гишүүн 42 настай филиппиний иргэн амиа алдаж, дөрвөн хүн гэмтэж бэртсэн байна. Таван хүн суулгасан аврах завь хөлгийн гавцангаас буюу 10 метрийн өндрөөс далай руу унасан байна. Гэмтсэн хүмүүсийн гурав нь филиппин, нэг нь

Энэтхэгийн иргэн ажээ. Тэдний хоёрынх нь биеийн байдал туйлын хүнд байгаа юм байна. АНУ-ын Флорида мужид байрлах төв нь байрлах "Royal Caribbean International" байгууллагад дэлхийн хамгийн том хөлөг онгоц харьяалагддаг юм. Тус хөлөг энэ оны тавдугаар сараас иргэдэд үйлчилж эхэлсэн байдаг. Хөлгийн өргөн нь 66 метр, урт нь Парисын Эйффелийн цамхагаас 50 метрээр их буюу 362 метр бөгөөд одоогоор дэлхий дээрх хамгийн том хөлөг онгоцонд тооцогдож байна.

Их Британи хуванцар мөнгөн дэвсгэртээ танилцуулла

Их Британи анхны хуванцар мөнгөн дэвсгэртээ танилцуулжээ. Английн банкны мэдэгдсэнээр, энэ мөнгөн дэвсгэртэйг цаасан мөнгөтэй харьцуулахад дуурайлган хийхэд хэцүү бөгөөд бат бөх ажээ. Таван фунт стерлингийн полимер мөнгөн дэвсгэртэйг өчигдрөөс гүйлгээнд оруулжээ. Үүнийг маш нимгэн бөгөөд уян хатан хуванцар материалаар хийсэн байна.

Үүний хувьд 6.6 ам.доллартай тэнцэх уг мөнгөн дэвсгэртэйг ар тал дээр Ерөнхий сайд асан Уинстон Черчиллийн хөрөг зургийг байрлуулжээ. Энэ мөнгөн дэвсгэртэйг хэмжээг өмнөх таван фунт стерлингийн цаасан мөнгөн дэвсгэртэй харьцуулахад 15 орчим хувь жижиг гэнэ. Тус улсын Төвбанк мэдэгдэхдээ "хуванцар мөнгөн дэвсгэрт нь нууцлал өндөртэй тул дуурайлган

хийхэд амаргүйгээс гадна бат бөх материалаар хийсэн учраас таван жил орчмын хугацаанд гүйлгээнд байх боломжтой" гэв. Өөрөөр хэлбэл, цаасан мөнгөнөөс 2.5 дахин удаан эдэлгээтэй гэсэн үг. Английн банк 10 фунт стерлингийн полимер мөнгөн дэвсгэртэйг 2017 оны дундуур, 20 фунтын мөнгөн дэвсгэртэйг 2020 он гэхэд гүйлгээнд гаргахаар төлөвлөж байгаа юм байна.

MMINFO тал нутгийн цахим мэдээлэл. Тал нутгийн өдөр тутмын мэдээ мэдээлэл таны гарт... Татах Play Store, Татах App Store.

# ОНЦЛОХ ХУУДАС

## ÖYÍ íü ÖYÍ áý?



# НАЙРААТАЙ, НАМЫНХАА

## “ЭРХИЙН ТЭНЭГ”

Х.НОРЖИН

Монгол бөхийн түүхэнд хамгийн олон удаа түрүүлсэн, бөхчүүдээс анх удаа байнгын ажиллагаатай парламентад сонгогдсон дархан аварга, УИХ, Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайд Б.Бат-Эрдэнийг “Хэн нь хэн бэ” буландаа онцоллоо.

Гэрэл зургийг Г.АРТУУЖИН

**Хоёрхон тушаалд гарын үсэг зурсан сайд**

Энээрхэм Батланхамгаалахын сайдаар томилогдоод 60 шахам хоног гэж байна. Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн бүтэн байдлыг хамгаалах үүрэг бүхий салбарт тойм тоогоор 10 гаруй мянган албан хаагч ажилладаг. Зэвсэгт хүчин гэх өнөр өтгөн айлын өрхийн тэргүүний хувьд тэрбээр ажлаа хүлээж авсаар ердөө хоёрхон тушаалд л гарын үсэг зурснаас өөрийг хийгээгүй бололтой. Энэ тухайгаа сэтгүүлчид өгсөн ярилцлагаадаа “Би сайдын албыг хүлээж аваад хоёр тушаал гаргасан. Эхнийх нь төсөв хэмнэлтийн зарчмаар ажиллах, нөгөөх нь дэг журмыг сахиулах чиглэлээр гаргасан тушаал шийдвэр юм. Тушаалын хэрэгжилтийг хангуулж ажиллуулахаар ажиллаж байна даа” гэжээ. Тэгэхээр мань эрд өнгөрсөн хугацаанд эхлүүлсэн, санаачилсан ажил байхгүй болж таарах нь. Уг нь өдийд хольг нь байг гэхэд Улаанбаатар хот орчмын анги нэгтгэлүүдийн өвөлжилтийн бэлтгэлтэй танилцаад зогсохгүй энэ хавар цэрэгт татагдсан хэдэн бор цэргээ эргэж амжих байлаа. Үүгээр түүгээр явсан гэж ярих зүйл үгүйг бодоход өрөөндөө тухласаар хоног өдрүүдийг барсан хэрэг. Ингэж хэлэхээр би учиргүй их ажил хийсэн. Өдөр бүр гадны зочид төлөөлөгчдийг хүлээн авч уулзаж байсны зэрэгцээ төсвийн тодотгол, Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийг батлахад цаг зав, мэдлэг оюунаа зориулсан хэмээх л байх. Энэ бүхнийг уншсан иргэд ямар гээч эрхэмд хамгийн хариуцлагатай салбараа хариуцуулчихав аа гэж нь дамжиггүй. Сургаар бол мань эр Батлан хамгаалахын сайдын суудлыг ирэх оны Ерөнхийлөгчийн сонгуульд оролцохгүй “Нэрээ татна” гэсэн тохироотойгоор авсан гэж. “Бор шувуу”-ны шивнэсэн үг шүү. Үнэн эсэхийг нь батлаж чадахгүй. Гэхдээ л эр хүн, цаашлаад намдаа дөрвөнтөө суудал авч өгсөн УИХ-ын гишүүний хувьд Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайдаар томилогдож чадсан л нэгэн.

“Батлан хамгаалахын салбарыг Б.Бат-Эрдэнэс өөр хүнд даалгаж болсонгүй юу”, “Буруу дэвсэн шувуу” гэхчилэн эсэргүүцэж байсан нь эдүгээ архив болон үлджээ. Тэднээс ганц нэгийг нь ишилсэн ч болж байна.

“Бөхийн Нямдоржтой өрсөлдөвөл дэмжинэ. Буруу дэвдэг шувуут дэмжихгүй”, “Аэро Монголиа”-гийн хувьцаагаа зарсан гэсэн. Тэр мөнгө нь хаана байгаа бол” гэх зэргээр бичихийн зэрэгцээ мөр холбоод шоглочихож.

“...Урт нэртэй хууль санаачилж, уурхайчдыг амьдралгүй болгосон бөх

Уур савссан толгойгоо өндийлгөж, улсын Ерөнхийлөгчид санаархсан бөх

Хан Хэнтийг дампууруулж, халхад алдаршсан бөх

Сээлд казинодож, сүрхий хөлжсөн бөх

Ноолуур модоор занамалдаж, ноомой царайлсан бөх

Ган бөмбөлгөөр жонглёрддог гандан буурдаггүй харамч хүн...” хэмээн шогложээ. Мөн “Энхбаярын үед нил авлигачдын дунд сууж байсан мөртлөө дүнхүү царайлаад дуугүй суугаад байсан өөдгүй нөхөр” гэх хүн ч байх юм. За тэгээд, цаашаа ухвал “Аварга дээд сургууль хоёр тэрбумаас багагүй, Чандганы аж ахуй, Хэнтийн гурилын үйлдвэрээ яасан бэ. Ард түмнийг юу ч мэддэггүй гэж санаав уу”, “Коммунистуудын авлига хээл хахууль авдгийг, Монголын газар шороо, ард түмнээр тоглолтийг мэдсээр байж дулий дүмбэ царайлаад сууж байдаг өөдгүй новш”, “Улс төрд ороогүй бол хүндлэгдээд сайхан л явах байж дээ, муу юманд хутгалдаад нэр нь ч унаж байна даа”, “Энэ яахаараа ийм олон малтай болдог байна. Ард түмний өгсөн малыг цуглуулаад л явдаг юм биз дээ, ичээч. Тээр жил Өвөрхангайгаас Цэрэнтогтох суурь хонь ард түмэн өглөө гээд туугаад. Туусан хүнээ дутаалаа гээд бөөн юм болсон доо” гэхчилэн явж өгчээ. Энэ бол сайтад зочилж, түүний талаархи мэдээлэлд үлдээсэн иргэдийн сэтгэгдэл.

Монгол түмний хайртай бөх

**Хараалын үгэнд булагдсан нөхөр**

Түүнийг Засгийн газрын гишүүнээр томилогдоход ард түмэн дуртай хүлээж аваагүй. Ямар сайндаа л цахим хуудсаар

самбо бөхийн дэлхийн аваргад гурвантаа түрүүлж, сонирхогчдын сумо бөхийн дэлхийн аварга цол хүртсэн амжилтыг үгүйсгэх эрх байхгүй. Цагтаа жинхэнэ монгол эрийн бяр чадлыг харуулж л явсан сайхан бөх. Харамсалтай нь эдүгээ эд хөрөнгө, хүн чанаргүй, харамч зангаасаа болж нэр хүнд нь жаахан уначихаад байгаа болохоос биш. Тэрбээр авыгаа дагаж наадам үзэж явсаар бөхөд хорхойтой нэгэн болсон гэнэ билээ. Өөрөө ингэж дурссан байдаг. Харин бөх болох замыг нь зааж, бөхийн дэвжээний хөтөлсөн ачтан нь хадам аав нь. Тодруулбал, Хэнтий аймгийн Батноров сумын уугуул, улсын заан Барамсай гуайг гэлцдэг. Гэхдээ аварга бөхийн удамтай. Төрсөн ээж Норжмаа нь Хөвсгөл аймгийн Цагаан-Үүр сумгийн хурц арслан Бадамсэрээжидийн дүү охин аж. Б.Бат-Эрдэнэ аварга залуудаа “Хүч” спорт хорооны нэрээр барилддаг байв. Түүнийг Сэлэнгэ аймагт цэргийн алба хааж байхад гавьяат багш Гэлэг “Хүч” нийгэмлэгт оруулжээ. Аварга үндэсний бөхөөс гадна жудо, самбо, сонирхогчдын сумо бөхийн хэд хэдэн төрөлд хүч сорьж явсныг нь түмэн мартаагүй биз ээ. Б.Бат-Эрдэнэ анх 1985 оны наадмын дөрвийн даваанд Увс аймгийн харьяат Улсын заан Тулгаа гуайг даваад, тавын даваанд улсын начин Балжиннямыг давж улсын начин, 1989 онд аварга улмаар 1990 онд дархан аварга, даян аварга цолыг тус тус хүртсэн.

Нэр төртэй бөхөөс мэргэшсэн эрхзүйч

Харин хувь хүний зан Хараншингийн тухайд “Аварга шиг зангарагтай явах хэрэгтэй” гэх магтаалын үгийг сонсч байгаагүй. Түүнийг улс төрд хөл тавихад нь Засгийн газрын гишүүнээр томилогдох үеийнх шиг нь л элдэв үгээр гоочилж эхэлсэн байх юм. Бөхчүүд барилдаж явснаас номын хуудас эргүүлж, тархиа цэнэглэсэн нь юу л бол гэхчилэн. Үнэндээ ч бөхчүүд дээд сургуулийн нэрийн өмнөөс барилдаж явсаар сурсан эрдмээр маруухан хэрнээ диплом өвөртөлдөг нь үнэн. Манай ангид ч жилдээ дөрөв, тав үзэгдээд сураг тасардаг бөхөндөөр хоёр байсан юмдаг. Тэр хоёр маань биднээс хойш гурван жилийн дараа их сургуулиа төгссөн байсан. Ямар замаар төгссөн нь ч ойлгомжтой. Мань эр ч ЦНДС-ийг тиймэрхүү маягаар төгссөн байхыг үгүйсгэхгүй. Лав гоц гойд оюутан байсан талаар магтаалын

үгийг өнөө хэр хэн нэгэн багш, хамт суралцаж байсан сонсогчид нь унагасныг олж уншаагүй, сонссонгүй. Гэхдээ түүнд бусдад үзүүлэх диллом буй. ЦНДС эдүгээ БХИС болж статус нь өөрчлөгдсөн. Эдүгээгийнхээр бол тус сургуульд эрхзүйч мэргэжлийн энгийн ангид сурч эзэмшдэг. Тэгэхээр цэргийн мэргэжлийн хүн гэж хэлж болох эсэхийг хэлж мэдэхгүй нь. Хэрэв үгүй бол тэрбээр мэргэшсэн Засгийн газрын мэргэжлийн бус сайдуудын нэг болж таарч байгаа юм. Харин эрх зүйчийн хувьд чадалтай, чадвартай нэгэн болсон нь дамжиггүй. Яагаад гэвэл УИХ-д дөрвөнтөө суухдаа хуулийн төслийг боловсруулж, цоорхойтой хууль болж уу, үгүй юу гэдгийг мэддэг, мэдэрдэг, анзаардаг болсон байлгүй. Хууль зүйн байнгын хорооны даргаар ажиллаж байсныг нь бодоход ч тэр.

Олны саналаар улс төрд хөл тавьсан нэгэн

Энэ бол өөрийнх нь хэлсэн үг. Бур тодруулбал, Батлан хамгаалахын сайд Б.Бат-Эрдэнэ Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшин өрсөлдөх үеэрээ тараасан сурталчилгааныхаа материалд ашигласан ярилцлагаадаа улс төрд хөл тавьсан үеэ “Биений тамрирын салбарынхан болон нутгийнхан маань санал тавьсны дагуу би улс төрийн амьдралд орсон” хэмээн тайлбарласан нь бий. УИХ-ын сонгуульд 2004 онд Хэнтий аймагт МАХН-аас нэр дэвшин ялалт байгуулсныхаа дараа Биений тамрирын тухай хуулийн төслийг боловсруулж, УИХ-д өргөн барьж, спортын салбарынхныхаа ачийг хариулсан. Нөгөөтэйгүүр, мань эр адтай байж мэдэх улстөрч. Сонгогчдод таалагдах зүйлийг хэзээ ямар нөхцөлд барьж авахаа мэднэ. Өнгөрсөн дөрвөн жилд гэхэд УИХ-ын Байгаль орчны байнгын хорооны идэвхитэй гишүүн нь байж Байгаль орчин, Ашигт малтмалын лицензтэй холбоотой асуудлаар үе үе хэвлэлийн бага хурал зарлан хуралдуулж, сонгогчиддоо өөрийгөө рекламдаад амжсан. Яах вэ, их ярьж бага хийдэг нөхдүүдийг бодвол Байгаль орчин, Ашигт малтмалын тухай хуулийн төсөл дээр ажиллаж, санаа оноогоо тусуулж чадсан гишүүн. Бас үе үе намынхаа эсрэг дуугарч, сүрийг үзүүлэх нь бий. “Оюу толгойн гэрээ Үндсэн хууль зөрчсөн” хэмээн нэр бүхий найман гишүүний хамт Ерөнхий сайд С.Батболдыг огцруулахыг шаардаж байсан

удаатай. Хааяахан бас намдаа тунирхаж сүйд болно. Нам нь ч мөчөөгөө өгөхгүйг хичээдэг ч эцсийн дүндээ аварга дандаа л дийлсэн байдаг юм. Дөрвөн удаа намдаа суудал авчирсан түүнийг “эрхлүүлэхгүй” гээд ч яалтай. Ерөнхийлөгчийн сонгуульд орон нутагт ялалтын тугийг атгаад алдсан юм шүү дээ. Энэ бол Монголын эгэл ардууд бөхдөө хайртайн илрэл ингэж харагдсан хэрэг.

Талаар дүүрэн малтай сайд

УИХ-ын гишүүн Б.Бат-Эрдэнэ АТТ-г хөрөнгө орлогын мэдүүлгээ гаргаж өгчээ. Тэрбээр жилийн 19 сая 470 мянган төгрөгийн орлоготой бөгөөд гэр бүлийн бусад гишүүд нь өнгөрсөн жил 14 сая 80 мянган төгрөгийн орлого олсон гэнэ. Хөрөнгө орлогын мэдүүлгээс нь харахад тэрбээр хувийн орон сууц, нэг үйлчилгээний барилгатай юм байна. Эдгээр нь нийлээд 425 сая 300 мянган төгрөгөөр үнэлэгдэх аж. Мөн “Сузуки гранд витара”, “Лексус 470” гэсэн хоёр машинтай гэнэ. Мөнгөнд чанга ханддагаараа алдартай бөх маань хот дотор дунд гарын жижиг жилийн машинаа унаж яваа харагддаг. Зарим хүн ингэж явааг нь хараад нэр төр олох гэж ядах юм. Энэ л ланд авч чадахгүй байв гэж ирээд л өө хайх нь бий. Юугаа унаж, юу идэх нь хувь хүний асуудал болохоор юу хэлэх вэ. Үүндээ тэр сүйхээтэй нэгэн шүү дээ. Хуулийн төсөлтэй ноцолдож өдрийг бардаг хүн биш. Хэнтий аймгийн өнгөтэй өөртэй бүхний өөрийн болгож чадсан нөхөр хэмээн нутгийнхан нь ярьдаг л юм билээ. Чандганы САА гэж байсныг бүхий л барилга объектийг хувьчилж авсан гэсэн сураг дуулдаг. Ямартай ч сайд маань нэлээд хэдэн компанийн хувьцааг эзэмшидэг гэдгээ АТТ-аас нуусангүй. Хөрөнгө орлогын мэдүүлгээ дурьдсанаар бол “Буудайн цацал” ХХК-ийн 20, “Атар чандгана” ХХК-ийн 51, “Атар чандгана сүү” ХХК-ийн 14 хувийг тус эзэмшдэг ажээ. Хадгаламжиндаа 30 сая 422,6 мянган төгрөгтэй, 10 сая төгрөгөөр үнэлэгдэх эзэмшил газартай гэж мэдүүлжээ. Даян аварга Б.Бат-Эрдэнэ бол УИХ-ын болоод Засгийн газрын гишүүд дундаас хамгийн олон малтай нь бас хамгийн олон хурдан удмын адуутай нь. Түүний нэр дээр 400 бод, 3100 бог, 20 хурдан удмын адуу байдаг. Эдгээр нь нийлээд 182 сая төгрөгөөр үнэлэгджээ.



# ЧУХАЛ ХҮН



Гэрэл зургийг Г.АРВҮУЖИН

гурван том төвийн нэг нь манай сургууль гэж боддог. Ингэж хэлснээр бусад сургуулийг үгүйсгэж байгаа юм биш. Ямар ч байсан багш бэлтгэдэг сургуулийн тэргүүн эгнээнд манай сургууль явдаг. Монголын Боловсролын үнэлэмжийн сайныг ч, саарыг нь ч үүрэх эрхтэй сургууль. Тиймээс сургуулиараа бахархдаг. Монгол Улсын Засгийн газар анхны Төрийн ордноо хүртэл сургууль болгож өгсөн нь ч гэсэн боловсролын салбарт хэрхэн анхаардаг байсны илэрхийлэл байх. Бидний сууж буй энэ танхим 1930 онд баригдсан Монгол Улсын анхны Төрийн ордон юм шүү дээ.

**-Хэл шинжлэлтийн ухааны доктор Ч.Чимэгбаатар таныг Монголын хэл шинжлэлийн сэтгэлгээг шинэтгэгч гэж тодорхойлсон байсан?**

-Мэргэжил нэгтэй хэдий ч, миний гарын шавь биш атлаа Монгол хэл шинжлэлийн түүхийг бичдэг дунд үеийн эрдэмтдийн нэг Ч.Чимэгбаатар "Монголын хэл шинжлэлийн сэтгэлгээг шинэтгэгч эрдэмтэн Ц.Өнөрбаян" гэсэн ном бичсэн байсан. Шинэтгэсэн гэдэг арай том нэршил болов уу. Миний бичсэн ном зохиолыг үзээд "шинэтгэгч" гэж үнэлсэн юм билээ. Сайхан ном бичсэн байхад нь арай дэндүүлчихсэн байна гэж хэлэх хэрэгтэй эсэхийг сайн

хэлж мэдэхгүй юм.

**-Та хэчнээн ном бүтээсэн бэ?**

-Бие дааж, бусад эрдэмтэдтэй хамтарч гаргасан ном сурах бичгийн тоо гэвэл 40 гаруй бий. Монгол хэлний сургалт судалгаатай холбоотой номууд голдуу бичдэг. Мөн 100 шахам өгүүлэл бий. Өөрийн уншиж буй лекцээ ч нэг ном гэж боддог.

**-Ажлын өрөөний тань ширээн дээр япон, англи, орос хэл дээрх хэл шинжлэлийн ном их байна. Хэдэн орны хэлээр ярьж, уншдаг вэ?**

-Би олон гадаад хэл мэддэг хүн биш. Хүнд гадаад хэлний хэрэгцээ ямар байна, түүндээ тохируулж сурах хэрэгтэй юм болов уу гэж боддог. Орос хэлээр мэргэжлийн ном зохиолыг уншижиддаг. Өөрийнхөө төвшинд ярьчихдаг. Унгарт эрдмийн зэрэг хамгаалахдаа унгар хэлийг сурсан. Унгар хүнийг яаж гүйцэх вэ, гэхдээ тодорхой төвшинд ярьж, уншдаг. Орчуулга хийдэг. Харамсалтай нь унгар хэл их явцуу хүрээнд хэрэглэгддэг л дээ. Англи хэлээр мэргэжлийн ном зохиолыг уншдаг. Ямартай ч, хүн гуйхгүй өөрөө уншичихдаг л юм.

**-Шавь нарын тоо хэд хүрч яваа бол. Гарын шавь бий юу?**

-Шавь нараа тоолж үзээгүй юм байна. 1971 оноос хойш МУБИС-д надаар хичээл заалгаж байсан

болон бусад улс орны шавь нар гээд нийгэд нь тооцвол 10 мянга гарсан байх. Бүх шавь л адилхан шүү дээ. Надаас ном сонссон бүх л шавьдаа би хайртай. Алдартай шавь нар ч олон байна. СГЗ, Чингис хааны одонт Г.Мэнд-Ооёо, Ш.Гүрбазар, Л.Гантөмөр зэрэг ардын багш, гавьяат ч олон бий. Олон улсын Монгол судлалыг хөгжүүлэх үйлсэд зүтгэж яваа гадаадын Монгол судлалын төвүүдэд ажиллаж буй шавь нар олон байна. Унгар, БНХАУ, ОХУ, Япон, БНСУ-д миний шавь нар олон бий. Монгол хэлийг сурья гэсэн хүн бүрт өөрийн чадлынхаа хэрээр сургагч юмсан, сонсогч юмсан гэж бодож явдаг даа.

**-Нэгэн үе дунд сургуулийн багш нарын чадвар сул байна гэх шүүмжлэл нийгэмд газар авч байсан. Сүүлийн жилүүдэд харьцангуй сайжирч байгаа юм болов уу даа. Энэ тал дээр таны байр суурийг сонирхмоор байна?**

-Би дээр дурьдсан. Нэг цаг үеийг нөгөө цаг үеийн шалгуураар дүгнэж болохгүй. 1940-1990-ээд оныг хүртэл эх хэлний сургалт академик маягийн хэлзүйд тулгуурласан, дүрэм заадаг сургалт байлаа. Тэр үед эх хэлийг хэрэглээний төвшинд сайн эзэмшдэг байсан. Зөв бичгийн дүрмийн алдаа гаргадаггүй, хичээнгүй бичдэг байлаа. Тэр үеийн ололт нь энэ.

1990-ээд оноос хойш дэлхийн боловсролын чиг хандлага руу ойртуулахын тулд хэрэглээний төвшинд хэлзүйд бус хэрэглээнд тулгуурласан сургалтын чанарыг сайжруулах талаар үе үеийн Засгийн газар анхаарал чадвар нь илүү хөгжсөн байдаг байх. 1990-ээд оноос хойш монголчуудын үндэсний сэтгэлгээ сэргэсэн. Эх хэл, соёлдоо хандах хандлага төр засгаас эхлээд жирийн иргэний тухайд ч харьцангуй сайжирсан. Шүүмжилж л байвал аливаа зүйл илүү хөгждөг шүү дээ. Төр засгаас эх хэлний боловсролд анхаарал хандуулж, 2003 онд Төрийн албан ёсны хэлний тухай хуулийг баталж байсанд баярлаж явдаг юм. Мөн монголчууд бичиг соёлын өдөртэй болж, Үндэсний монгол бичгээ сэргээх хөдөлгөөн ч хүчтэй өрнөж байна. Улмаар Ерөнхий боловсролын бүх сургуульд монгол бичгээ заадаг болсон. Монгол бичгийн орчин бүрдүүлэх талаар төрөөс олон арга хэмжээ авч байна. Тухайлбал, Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж монгол бичгийн хэрэглээг бий болгохын тулд

төрсний гэрчилгээ, диплом үнэмлэх, гадаадад явуулах албан бичгийг монгол бичгээр бичдэг болсон. Үүнийг чухал алхам гэж боддог. 2015 онд УИХ-ын нэр бүхий гишүүд санаачлан бидний эрдэмтэд ажлын хэсэгт нь багтаж, Төрийн албан ёсны хэлний тухай хуулийг өөрчилж, Монгол хэлний тухай хууль гаргасан. Ер нь монгол хэл, бичигт анхаарал хандуулж яваа төр засаг, багш нартаа баярлаж явдаг юм. Гэхдээ туйлширч болохгүй. Нэг бичгийг нөгөө бичгийн эсрэг тавьдаг, бичиг үсгэнд буруу өгдөг туйлширсан үзэл санаа байдаг. Аль ч бичиг үсэг хүн төрөлхтний хөгжилд асар том гавьяа байгуулсан. Монголд үндэсний бичиг болтлоо дархлаажсан бичиг бол Монгол бичиг. Кирил бичиг нь Монголын ард түмнийг зуун хувь бичгийн боловсролтой болгосон. Гагцхүү ямар бичгийг албан ёсны бичиг болгохоо төр шийднэ.

**-Сүүлийн үед янз бүрийн хэл хугалчих шахсан үг хэлтгүүд гарах болжээ. Үүнийг дагаад эх хэл маань мөхөж байна уу даа гэх хандлага аль хэдийнэ нийгэмд тарах болж. Энэ салбарт зүтгэж яваа хүний хувьд та ямар бодолтой байдаг вэ?**

-Эх хэлэндээ хайртай хүмүүс ингэж ярьдаг байх. Зарим нь "Хэл бохирдлоо", "Хэл мөхөх нь" гээд уйлах шахам ярьж л байдаг юм. Би арай өөдрөг үзэлтэй. Ямар ч хэл тухайн улс үндэстэн оршин тогтнох нэг дархлаа болж байдаг. Тухайн үндэстний соёл, сэтгэлгээг гэж явдаг хүчирхэг зэвсэг шүү дээ. Монгол хэл хэдийд үүссэнийг тодорхойлоход түвэгтэй. Ямартай ч, тодорхой нэг цаг үед үүссэн. Тодорхой нэг үед мөхнө. Үүссэн юм мөхөх нь жам. Хүн төрөлхтөн дуусах үед хэл ч гэсэн мөхнө. Гэхдээ дэлхийд урт удаан настай мөхөх аюул нь хол хэл гэж бий. Хэрэглэгч олонтой хэл мөхөх аюул багатай. Тухайлбал, англи, орос зэрэг хэлийг нэрлэж болно. Түүнээс гадна хэрэглэгч цөөтэй ч, мөхөх аюулаас хол хэл гэж байдаг. Монгол хэл хэрэглэгч цөөтэй. Албан ёсны бус мэдээгээр монгол хэлээр зургаан сая орчим хүн ярьдаг гэсэн тооцоо бий. Монгол угсаатан 10 гаруй сая байдаг гэж хүмүүс ярьдаг юм билээ. Монгол угсаатан бүр монгол хэлээрээ ярьдаггүй. Гэхдээ эхлэн зуун, эсвэл мянган хүн ярьдаг хэл бодвол монгол хэл харьцангуй гайгүй. Хэдий цөөн хэрэглэгчтэй ч монгол хэл мөхөх аюулаас хол хэлүүдийн нэг гэж би боддог. Монгол хэл мөхөх нь гэж айж балмагдаад байгаа хүмүүст би тайван байхыг зөвлөдөг юм. Тэд надаас яагаад гэж асуудаг. Үүнд гурван шалтгаан бий. Нэгдүгээрт, бичгийн хэлээр баталгаажсан хэл мөхдөггүй. Монголчууд бичгийн хэлтэй

шүү дээ. Өвөрмонголчууд монгол бичгээ хэрэглэж байгаа. Манайхан бол кирил, монгол бичгээ хослон хэрэглэж байна. Бичиг үсэг үүссэнээр хэл мөхөх хурдыг сааруулсан гэж хэлж болно. Хоёрдугаарт, монгол хэл олон аман аялгууны онго төрхтэй. Халх, ойрад, буриад, өвөр гэсэн дөрвөн том аялгуутай. Ойрад гэхэд дөрвөд, баяд, урианхай, захчин, өөлд гэх мэт тус бүр дотроо хуваагдана. Том найрал хөгжим мэт маш олон аялгуутай. Тэр аялгуунууд устаж, жижигрэн нэг аялгуунд шингэхэд магадгүй хэл мөхнө. Тиймээс аялгуугаа хамгаалах монгол хэл олон аялгууны нь дэлхийн бүх хэлэнд байдаг элемент монгол хэлэнд байдаг юм. Харь хэлний нөлөөнд автаж монгол хэл мөхөх магадлал тун бага. Гэхдээ харь хэлнээс үг авахдаа монголжуулж авах хэрэгтэй. Хятадаас авсан үг түмэн үг байна шүү дээ. Монгол нэртэй хоол тун цөөн. Ихэнх нь Хятадаас авсан байдаг. Жишээ нь, байцаа, лууван, бууз, хуушуур гэдэг үгийг хятад хүнд хэлбэл ойлгохгүй. Өөрийнх нь үг шүү дээ. Энэ бол харь үгийг монголчилж авсны нэгээхэн жишээ. Ийм арга аливаа хэлэнд маш чухал.

**-Монгол судлалын төвөөс сургуулийн ойлгой холбоотойгоор олон улсын чанартай томоохон эрдэм шинжилгээний хурлыг зохион байгуулж байсан?**

-Миний өднийг хүртэл хийсэн бүхий л зүтгэл минь Монгол судлалтай холбоотой байдаг. Монгол судлалын төвийг байгуулснаас хойш олон улсын эрдэм шинжилгээний гурван ч том хурлыг зохион байгуулсан байна. Гадаадын монголч эрдэмтэдтэй хамтраад эрдэм шинжилгээний бүтээлүүд хэвлүүлсэн. Сургуулийн болон улсын төсөлт ажил хэд хэдийг гүйцэтгэсэн байна. МУБИС-ийн Монгол судлалын төв гэх нэр хүндийг хэвээр хадгалахын төлөө зүтгэж явна. Гайгүй ажиллаж байгаа болов уу гэж дүгнэж байгаа. Эрүүл мэнд гайгүй бол багшлахын зэрэгцээ Монгол судлалын их үйлсдээ хүчин зүтгэнэ гэж боддог өөдрөг үзэлтэй хүн дээ, би.

**-Гэр бүлээ танилцуулна уу?**

-Би өдий зэрэгтэй яваад гэр бүлийнхний маань ач тус их шүү дээ. Миний ажил үйлсийг дэмжиж үр хүүхдийг минь өсгөн хүмүүжүүлж яваа эхнэртээ баярлаж явдаг. Намайг онгоцой өөдтэй, өдний зэрэгтэй авч яваа хүн бол миний эхнэр. Манайх хоёр хүүхэдтэй. Хоёулаа дээд боловсролтой. Ачнартаа хайртай жирийн л нэг сэхээтэн хүн дээ.

**-Таны мэргэжлийг өвлөсөн хүүхэд байна уу, танайд?**


-Одоогоор миний мэргэжлийг өвлөсөн хүн алга байна. Ач нараас хэн нэг нь өвлөх байх гэж найдаж суугаа шүү.

## АШИГТ МАЛТМАЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН 2016 ОНЫ 8 ДУГААР САРЫН ХӨДӨЛГӨӨНИЙ МЭДЭЭ

| №  | Т/З-ийн дугаар | Аймаг, хот | Сум, дүүрэг  | Талбайн нэр      | Тусгай зөвшөөрөл эзэмшигч | Эзэмшигчийн регистр | Үндэслэл                                  | Шийдвэр-ийн огноо | Шийдвэр дугаар |
|----|----------------|------------|--------------|------------------|---------------------------|---------------------|---|-------------------|----------------|
| 1  | MV-000384      | Хөвсгөл    | Цэцэрлэг     | Могойн гол       | Могойн гол                | 2034859             | АМТ хуулийн 56-р зүйлийн 56.1.2           | 2016.08.03        | 563            |
| 2  | MV-015601      | Төв        | Алтанбулаг   | Налгар           | Царьлахад                 | 5432219             | АМТ хуулийн 56-р зүйлийн 56.1.2           | 2016.08.03        | 563            |
| 3  | MV-015604      | Ховд       | Мянгад       | Мянгад           | Жаргалант рашаант         | 4063481             | АМТ хуулийн 56-р зүйлийн 56.1.2           | 2016.08.03        | 563            |
| 4  | XV-008018      | Ховд       | Ээрэг        | Жаргалант-1      | Брэйвхарт ресорсиз        | 2878992             | АМТ хуулийн 53-р зүйлд заасан үндэслэлээр | 2016.08.02        | 0              |
| 5  | XV-012574      | Сүхбаатар  | Асгат        | Нүүрстийн хутаг  | Дорнын чулуулаг           | 5070287             | АМТ хуулийн 53-р зүйлд заасан үндэслэлээр | 2016.08.08        | 0              |
| 6  | XV-012620      | Хэнтий     | Батноров     | Ногоон хөндий    | Хүрээ дэл                 | 2697734             | АМТ хуулийн 53-р зүйлд заасан үндэслэлээр | 2016.08.11        | 0              |
| 7  | XV-012626      | Сүхбаатар  | Баяндэлгэр   | Намаржаа Толгой  | Гуосэн                    | 2890542             | АМТ хуулийн 53-р зүйлд заасан үндэслэлээр | 2016.08.11        | 0              |
| 8  | XV-012646      | Төв        | Онгон        | Майхант          | Бидникэн                  | 5194571             | АМТ хуулийн 53-р зүйлд заасан үндэслэлээр | 2016.08.23        | 0              |
|    |                |            | Баянцогт     |                  |                           |                     |   |                   |                |
| 9  | XV-012649      | Баянхонгор | Баян-Овоо    | Цагаан цахир уул | Алтанбумбат овоо          | 5542979             | АМТ хуулийн 53-р зүйлд заасан үндэслэлээр | 2016.08.23        | 0              |
| 10 | XV-012650      | Баянхонгор | Баян-Овоо    | Цахир Уул        | Гучингийн алт             | 5542936             | АМТ хуулийн 53-р зүйлд заасан үндэслэлээр | 2016.08.23        | 0              |
| 11 | XV-013834      | Баян-Өлгий | Буянт        | Орой уул         | ОАЭ                       | 5097711             | АМТ хуулийн 56-р зүйлийн 56.1.2           | 2016.08.03        | 563            |
|    |                |            | Толбо        |                  |                           |                     |   |                   |                |
| 12 | XV-013835      | Баян-Өлгий | Дэлүүн       | Оюут             | ОАЭ                       | 5097711             | АМТ хуулийн 56-р зүйлийн 56.1.2           | 2016.08.03        | 563            |
|    |                |            | Толбо        |                  |                           |                     |   |                   |                |
| 13 | XV-013838      | Өмнөговь   | Цогтцэций    | Арсантай         | Икс Эйч Кэй Эйч           | 5412013             | АМТ хуулийн 56-р зүйлийн 56.1.2           | 2016.08.03        | 563            |
| 14 | XV-014122      | Дорноговь  | Улаанбадрах  | Борзон-2         | Дорнын гэгээн үүл энержи  | 5421713             | АМТ хуулийн 53-р зүйлд заасан үндэслэлээр | 2016.08.04        | 0              |
|    |                |            | Хөвсгөл      |                  |                           |                     |   |                   |                |
| 15 | XV-016853      | Дорноговь  | Алтанширээ   | Тойром           | ВУС                       | 5228026             | АМТ хуулийн 53-р зүйлд заасан үндэслэлээр | 2016.08.08        | 0              |
| 16 | XV-017552      | Сүхбаатар  | Асгат        | Нүүрстийн хутаг  | Дорнын чулуулаг           | 5070287             | АМТ хуулийн 53-р зүйлд заасан үндэслэлээр | 2016.08.08        | 0              |
| 17 | XV-018010      | Завхан     | Завханмандал | Ембүү толгой     | Уникон                    | 5726743             | АМТ хуулийн 56-р зүйлийн 56.1.2           | 2016.08.03        | 563            |
|    |                |            | Ургамал      |                  |                           |                     |   |                   |                |
| 18 | XV-018253      | Говь-Алтай | Хохморьт     | Шарга            | Өмнийн улаач              | 5432855             | АМТ хуулийн 56-р зүйлийн 56.1.2           | 2016.08.03        | 563            |
| 19 | XV-018315      | Завхан     | Алдархаан    | Улаан хайрхан    | Хамаг монгол хуралдай     | 5001234             | АМТ хуулийн 56-р зүйлийн 56.1.2           | 2016.08.03        | 563            |
| 20 | XV-018319      | Говь-Алтай | Тайшир       | Цахирт           | Дуут хөндий               | 5074428             | АМТ хуулийн 56-р зүйлийн 56.1.2           | 2016.08.03        | 563            |
| 21 | XV-018585      | Ховд       | Буянт        | Эрдэнэт          | Алтайхангай мастерс       | 5662826             | АМТ хуулийн 56-р зүйлийн 56.1.2           | 2016.08.03        | 563            |
| 22 | XV-018634      | Баян-Өлгий | Толбо        | Санчир           | Универсал нобле майнинг   | 5793114             | АМТ хуулийн 56-р зүйлийн 56.1.2           | 2016.08.03        | 563            |

## АШИГТ МАЛТМАЛЫН ГАЗРЫН КАДАСТРЫН ХЭЛТЭС

# Нөлөөт толь



Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

### Н.ПУНЦАГБОЛД

**М**анжин байхад махаар яах вэ, Манж байхад Монголоор яах вэ гэдэг үг байдаг даа. Түүнтэй төстэй нэг үгийг УИХ-ын гишүүн Б.Батзориг хэлчихсэн. Юу гэхээр, хөшөө байхад хүүхдийн эмч, цагдаагаар яах вэ гэсэн маягтай. Яг тэгж тус тас хэлээгүй ч цаагуураа утга учрыг нь гүн гүнзгий ухвал иймэрхүү хэлцтэй ойролцоо байж болохоор байгаа юм. Мань хүн Баянзүрх дүүргийн Засаг даргаар ажиллаж байхдаа Чулуун овоо орчимд арслан, нохойны хөшөө

барилуагүй юу. Тухайн үедээ тэрбум төгрөгөөр туйлсан гээд л хэвлэлийнхэн шуугиад байлаа. Харин мань хүн нэгэн нэвтрүүлэгт оролцох үеэрээ энэ хөшөөнийхөө цаад нарийн учрыг тайлж, үнэ өртгийг нь ч хэлж. Үнэ нь тийм ч их биш, 280-хан сая юм билээ, хөөрхий. Тэгээд Баянзүрх дүүргийн шүтээн нь цагаан арслан. Баянзүрх хайрхны савдаг нь нохой юм гэсэн. Ингээд л арслан, банхарын хөшөө барихаар шийдэхгүй юу. Тэгэхдээ бас лам хуваргаас асууж, зөвлөлдсөн юм билээ. Гол нь тэр хөшөөг хөшөө гэдэг талаас нь биш шүтээн гэж харах ёстойг бас захисан. Өнөөдрийг хүртэл бидний хийгээд байгаа гол алдаа бол шүтээнийг хөшөө гэж хараад байгаад л байна.

За тэгээд, энэхүү шүтээнийг 280-хан сая төгрөгт багтаан барьсныдараа Баянзүрх дүүрэгт гэмт хэргийн гаралт багассан гэж байгаа. Хамгийн чухал нь хүүхдийн эндэгдэл буурчээ. Үүнийг бүр судалгаагаар

тогтоосон гэж байгаа юм. Зарим нэг сайдын хажууд эрхэм гишүүн бүр судалгаатай юм ярьж байгаа шүү. Энэ яриаг цаагуур нь ухаад үзвэл хөшөө байхад цагдаа, хүүхдийн эмчээр дутахгүй гэсэн далд утгыг илэрхийлж байна гэж мунхаглаад байна. Дээрээс нь Б.Батзориг гишүүний хэрэгжүүлсэн энэ ариун ажлыг дүүргийн Засаг дарга болгон үлгэр дуурайлал болгомоор байна. Хотын дарга ч гэсэн ялгаагүй. Сонгинохайрхан дүүрэг өнөөдөр гэмт хэргийн гаралтаараа нийслэлдээ дээгүүрт давхидаг. Хүүхдийн эндэгдэл ч ялгаагүй. Учир нь олон хүн амтай. Тэгвэл энэ мэт сөрөг үр дагаварыг бууруулахын тулд Сонгинохайрхан уулынхаа савдгийн хөшөөг Нэгдүгээр хороолол орчимд барьчихгүй юу. Сонгинохайрхан уулын савдаг нь архинд дуртай хөх өвгөн байдаг юм гэнэ билээ.

Тэгэхээр архи шимэн суугаа урт сахалтай, хөх өвгөний хөшөө барьчихвал гэмт

хэргийн гаралт аяндаа буураад болно. Хангарьд шувууны сүрлэг сайхан шүтээн барихад бол тэрбумхан төгрөг үнэхээр багдана. Тэгэхээр 2-3 тэрбумыг цацаад, хүн бүр шүтчихээр шүтээн барьчихаач дээ, хотын дарга аа. Аль хэдийнэ Баянзүрх дүүрэгт шүтээнээ босгоод, дараа нь гэмт хэрэг буураад, хүүхдийн эндэгдэл багассан нь судалгаагаар нотлогдчихоод байхад ийм сайн жишгийг улсад хэрэгжүүлэхгүй яваад байгааг л гайхаад байна. Манай хотын дарга С.Батболд баар, цэнгээний газрын хаах цагийг 00:00 цаг болгож чадаж байгаа юм чинь Б.Батзориг гишүүний туршлагыг бол олхон өлгөж авах байлгүй дээ. Эрхэм дарга нар минь, хүүхдийн эндэгдэл бууруулах гэж эмч нараа цаг наргүй ажиллуулж, эмнэлгийн тоног төхөөрөмжид мөнгө зараад юу хийнэ. Гэмт хэрэгтэй тэмцэнэ гээд л хэдэн цагдаагийнхаа үйлийг үзэж яана. Зүгээр л ахиухан мөнгө зараад, томхон шүтээн барьчих. Баянзүрхийн шүтээнээс илүү томыг барьчихвал гэмт хэрэг буурах биш бүр алга болох ч юм бил үү, хэн мэдлээ.

шүү. Тэрбумыг зарсан ч болно. Хангарьд шувууны сүрлэг сайхан шүтээн барихад бол тэрбумхан төгрөг үнэхээр багдана. Тэгэхээр 2-3 тэрбумыг цацаад, хүн бүр шүтчихээр шүтээн барьчихаач дээ, хотын дарга аа. Аль хэдийнэ Баянзүрх дүүрэгт шүтээнээ босгоод, дараа нь гэмт хэрэг буураад, хүүхдийн эндэгдэл багассан нь судалгаагаар нотлогдчихоод байхад ийм сайн жишгийг улсад хэрэгжүүлэхгүй яваад байгааг л гайхаад байна. Манай хотын дарга С.Батболд баар, цэнгээний газрын хаах цагийг 00:00 цаг болгож чадаж байгаа юм чинь Б.Батзориг гишүүний туршлагыг бол олхон өлгөж авах байлгүй дээ. Эрхэм дарга нар минь, хүүхдийн эндэгдэл бууруулах гэж эмч нараа цаг наргүй ажиллуулж, эмнэлгийн тоног төхөөрөмжид мөнгө зараад юу хийнэ. Гэмт хэрэгтэй тэмцэнэ гээд л хэдэн цагдаагийнхаа үйлийг үзэж яана. Зүгээр л ахиухан мөнгө зараад, томхон шүтээн барьчих. Баянзүрхийн шүтээнээс илүү томыг барьчихвал гэмт хэрэг буурах биш бүр алга болох ч юм бил үү, хэн мэдлээ.

## Дүүрэг болгон савдгийнхаа

## Шүтээнийг босгочихооч...

### Улаанбаатарт:

Маргааш  
Өдөр -9  
Шөнө -1

Нөгөөдөр  
Өдөр -9  
Шөнө -4

### Өдрийн зурхай

Намрын дунд улаагчин тахиа сарын Нэг цагаан мэнгэтэй Цагаан хулгана өдөр. Бархасбадь гараг

Үс засуулбал:  
Эд, мал арвидна  
Наран ургах, шингэх:  
06:35 - 19:07



Өдрийн өнгө: Тухайн өдөр бич жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба үхэр, луу, хонь, нохой жилтнээ сөрөг туу нөлөөтэй тул элдэв үйлд хяналттай хандаж, бие энхрийлүүштэй. Эл өдөр хууль цааз гаргах, батлах, хэрэглэх, хулгай дээрлийг нотхотгох, гэлтнийг шийтгэх, мал адегус нотхруулах, угаал үйлдэх, хүүхэд үрчлэн авах, урлан бүтээхэд сайн. Улааны үйл, төлөг тавих, морь уралдахад туу. Өдрийн сайн цаг нь хулгана, үхэр, туулай, морь, бич, тахиа болно. Хол газар яваар одогосод зүүн урагш төрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулбал эд, мал арвидна.

### ДУУЛГАХ СОНИН

## Загвар өмсөгч Н.Ану ХАТАН ХААНЫ ТӨЛӨӨ ӨРСӨЛДӨНӨ

“MISS TOURISM QUEEN INTERNATIONAL” тэмцээн Хятадын Аялал жуулчлалын шинэлэг бүс болгон хөгжүүлж буй Пинь Янь хотод энэ сарын 12-нд эхэллээ. Тус тэмцээнд эх орноо төлөөлөн Загвар өмсөгч, мисс Н.Ану оролцож байна. Тэрбээр Азийн супер модель бөгөөд эх орноо төлөөлж Дэлхийн миссийн тэмцээнд оролцож байсан туршлагатай нэгэн. Энэхүү тэмцээнд 2007 онд манай улсаас анх удаа загвар өмсөгч, мисс Г.Оюунгэрэл оролцож Ази тивийг

төлөөлсөн шагналт байранд шалгарч “Азийн хатан хаан” хэмээх өргөмжлөл хүртсэн билээ. “MISS TOURISM QUEEN INTERNATIONAL” тэмцээн нь нэг үндсэн ялагчаас гадна таван тивийн төлөөлөл болгож таван бүсгүйг тивийн хатан хаанаар шалгаруулдаг онцлогтой юм. Мөн манай улсаас тэмцээний зохион байгуулагчдын урилгаар Азийн топ фэйшн фото зурагчин шагналт Ж.Батсайхан оролцогчдын зураг авалтын ажилд оролцож байгаа аж.

### Бидэнд тохиолдсон



Рэнцэн Оюунгэрэл

Зургаан настнуудын паян дуусдаггүй билээ. “Ээжээ уржигдар гэдэг чинь хоёр хоногийн өмнөхийг хэлж байгаа юм бол гуржигдар гэж гурав, дөржигдөр гэж дөрөв, тавжигдар гэж тав, зуржигдар гэж зургаа хоногийн өмнөхийг хэлж болох юм байна тийм ээ” гэнэ ээ. Тэгээд л цаашаагаа должигдор, наймжигдар, есжигдөр, аржигдар гээд л явах юм байх өө гэдэг байгаа. Золигийн ч юмаа даа энэ хүүхдүүд.

АМЕРИКИЙН КИНО

Зөвлөх байгуулагч

Хамтран зохион байгуулагч

2016 оны 9 сарын 15-17  
Тэнгис кино театрт  
улсуудын тус тус  
11pm, 1pm  
#AFSMongolia

**АМЕРИКИЙН КИНО ӨДӨРЛӨГ 2016**  
ТЭНГИС КИНО ТЕАТРТ 2016.09.15-17-НЫ ХОРООНД  
ЗОХИОГДОНО. ТАСАЛБАР ҮНЭГҮЙ

АМЕРИКИЙН КИНО  
2016.09.15-нд  
19:00 цагт

АМЕРИКИЙН КИНО  
2016.09.16-нд  
19:00 цагт

АМЕРИКИЙН КИНО  
2016.09.16-нд  
21:00 цагт

АМЕРИКИЙН КИНО  
2016.09.17-нд  
17:00 цагт

АМЕРИКИЙН КИНО  
2016.09.17-нд  
19:00 цагт